



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/34

Номгон


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310089

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 24/34 дүгээр захирамжийн хавсралт



**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд салбар хоорондын уялдаа холбоог хангах, хүчирхийллийн хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд хамтран хэрэгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

Үр нөлөө: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шуурхай таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдаа холбоо, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх байдлаар хүчирхийллийн хохирогчдлын аюулгүй байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэгчийн үйлдлийг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэж, тэдний зан үйлд нөлөөлөх байдлаар хамтран ажиллах

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Шаардагдах төсөв
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг тодорхой хувиар бууруулсан байна.							
1	Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар үр дүнг нэмэгдүүлэх, сургалтыг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх	Сургалт	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурна, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд өөрчлөлт гарна	Цагдаагийн газар	Төрийн бус байгууллага,	2023 он	-

1	2	3	4	5	6	7	8
2.	Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, нөлөөлөл хандлагыг нэмэгдүүлэх, хүчирхийллийн хэлбэрүүд болон хууль эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, гарын авлага, тараах материал, видео шторк зэргийг өвөрмөц байдлаар бэлтгэн иргэдэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд мэдээлэх,	Гарын авлага, тараах материал, шторк	Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, хандлага нэмэгдэнэ	Цагдаагийн газар	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд	2023 он	-
3	Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн загвар болгох зорилгоор хэрэгжүүлж буй "Шар карттай өрх" -ийн үйл ажиллагааг дэмжих, бусад багуудад бий болгох	Гэрээ байгуулах	ГБХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо сайжирна.	Цагдаагийн газар	АЗДТГ-ын НБХ Иргэд, сайн дурын бүлэг, нөхөрлөл, холбоо	2023 он	-
5.	Хамтарсан багийн гишүүдтэй хамтран хүчирхийлэлд өртөж буй зорилтот бүлгийг тодорхойлон "Гэрийн эргэлт" зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах,	Уулзалт, сургалт	Хүчирхийлэл үйлдэгчид тавих хяналт сайжирна	Цагдаагийн газар	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хамтарсан баг	2023 он	-
6	Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр төлбөртэй мэдээлэл авах журмыг хэрэгжүүлэх, сурталчлах	Журмын хэрэгжилтийг хангах	Гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал хэлбэрт орохоос урьдчилан сэргийлнэ	Цагдаагийн газар	АЗДТГ-ын ХЭЗХ	2023 он	-

1	2	3	4	5	6	7	8
7	Гэр бүлийн хүчирхийлэл удаа дараа үйлддэг иргэдийг хамтарсан багийн саналыг үндэслэн “Жаргалтай амьдрал” төвд хэвтүүлэн эмчлүүлэх ажлыг зохион байгуулах	Албадан эмчилгээ	Хүчирхийлэл үйлдэгчийн архи согтууруулах ундааны хэрэглээ багасна	Цагдаагийн газар	ГХУСАЗЗ	2023 он	-
Зорилт 2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хохирогчдын нууцлал болон аюулгүй байдлын хангаж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах							
1	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих, эцэслэн шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудын ойлголт хандлагыг нэгтгэх чиглэлээр сургалт, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг шүүхийн шийдвэрт тусгуулан хэрэгжүүлэх,	Сургалт, Зөвлөгөөн	Эрх бүхий албан тушаалтнуудын ойлголт хандлага сайжирч, хохирогчийн аюулгүй байдал хангагдана	Цагдаагийн газар	Прокурорын газар, Шүүхийн тамгын газар	2023 он	-
2.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа ашиглах, салбар хооронд мэдээлэл солилцох,	Сан бүрдүүлж ашиглах	Статистик тоон мэдээллийн чанар, үр дүн дээшилнэ	Цагдаагийн газар	-	2023 он	-
Зорилт 3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдогч нарт шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх таатай орчин бүрдүүлэх							

1	2	3	4	5	6	7	8
1	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон насанд хүрээгүй хүүхдүүдтэй уулзах, тайвшруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг тусгайлан тохижуулах тооцоо судалгаа гарган тохижуулж, үйл ажиллагаандаа ашиглах	Өрөө тохижуулах	Хохирогчдын сэтгэл зүйд эергээр нөлөөлнө, нууцлал хангагдана.	Цагдаагийн газар	Хууль, эрх зүйн хэлтэс	2023 он	
2.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нар чиглэсэн биеэ хамгаалах болон бусдад мэдээлэл өгөх чадварт сургах чиглэлээр зорилтот видео, тараах материал бэлтгэж түгээх	Гарын авлага, тараах материал, шторк	Хохирогчдын биеэ хамгаалах чадвар нэмэгдэж, хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.	Цагдаагийн газар	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд	2023 он	-
3.	Эцэг, эх байх үүргээ биелүүлэхгүй, хүүхдээ асран хамгаалах үүрэгтээ хайнга хандаж буй эцэг эхчүүдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, салбар хоондын уялдааг хангах	Сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажил, аян	Иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэнэ	Цагдаагийн газар	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	2023 он	-
Зорилт 4. Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага, чадварыг эзэмшүүлэх							
1.	Эцэг, эх байх үүргээ биелүүлэхгүй, хүүхдээ асран хамгаалах үүрэгтээ хайнга хандаж буй эцэг эхчүүдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах,	Сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажил, аян	Иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэнэ	Цагдаагийн газар	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	2021 он	-
1	2	3	4	5	6	7	8

	салбар хоорондын уялдааг хангах						
2	Хүчирхийллийн улмаас гэр бүлээ цуцлуулсан хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хуульд заасан хязгаарлалт хэрэглэх.	Шийдвэр гаргуулах	Хохирогчийн аюулгүй байдал хангагдана	Цагдаагийн газар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2023 он	-
Зорилт 5 Иргэдэд хууль зүйн мэдлэг, эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх;							
1.	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтот бүлэгт /малчин эмэгтэйчүүд, төрийн алба хаагч, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ чиглэсэн сургалт зохион байгуулах.	Сургалт	Зорилтод бүлгийн иргэдийн эрх хангагдана.	Цагдаагийн газар	НЦҮТ	2023 он	-
2.	Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийг сурталчилсан тэмцээн уралдаан зохион байгуулж, олон нийтэд сурталчлах.	Тэмцээн, уралдаан	Нийгэмд эерэг ойлголт бий болно.	Цагдаагийн газар	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	2023 он	-